

# **ГААЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН**

---

Улаанбаатар хот  
2021 он

## **ГААЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН**

Гаалийн тухай хууль нь 2008 онд батлагдаж, хуулийн зорилтоор Монгол Улсын гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн бүрдүүлэлт хийх, гаалийн хяналт хэрэгжүүлэх журам, гаалийн бүрдүүлэлтийн горим, нөхцөл, шаардлагыг тогтоох, гаалийн байгууллагын тогтолцоо, гаалийн байгууллага, албан тушаалтны эрх, үүргийг тодорхойлох, тэдгээрийн шийдвэрт иргэнээс гомдол гаргах, түүнийг гаалийн байгууллага, албан тушаалтнаас шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулж байна.

Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог аргачлалын дагуу тооцохын зорилго нь иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардлын ачааллыг тооцож, цаашид гарах ачааллыг багасгах санал боловсруулахад энэхүү судалгааны зорилго оршино.

Уг аргачлалын 1.5 дахь хэсэгт заасан журмын дагуу Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн тухайд төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдэд оногдох зардал байгаа эсэхэд тооцож үзэв.

### **1. Иргэн, хуулийн этгээдэд үүсэх зардал**

Монгол Улсын Их Хурлын 2015 оны 85 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс" баримт бичгийн эдийн засгийн чиглэлд "Батлан хамгаалах арга хэмжээний зардлыг Монгол Улсын төсвөөс болон хуульд заасан бусад эх үүсвэрээс санхүүжүүлнэ. ..." гэж заасан ба манай орон зохион байгуулдаж байгаа олон улсын цэргийн хээрийн сургууль, дадлагад гадаад улс орны цэргийн багийн бүрэлдэхүүний зэвсэглэл, цэргийн техник, тоног төхөөрөмжийг улсын хилээр нэвтрүүлэхэд гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулах горимд байршуулах бараанд гаалийн байгууллага импортын гаалийн болон бусад татвар ногдуулж, хураан авч, төрийн сангийн тусгай дансанд байршуулна гэсэн эрх зүйн зохицуулалтад энэхүү асуудлыг хамаарахгүй байх эрх зүйн зохицуулалтыг Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар бий болгосноор иргэн, хуулийн этгээдэд нэмэлт зардал үүсэхгүй болно. Өөрөөр хэлбэл, улсын төсвөөс зарцуулах тодорхой зардлаас нэмэлт зардал гарахгүй гэж ойлгож болох юм.

### **2. Хуулийн төсөлтэй холбогдуулан төрийн байгууллага буюу улсын төсөвт үүсэх зардал**

Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцохдоо хуулийн төсөлд тусгагдсан зардал гарах агуулга бүхий заалтыг тодорхойлж, улмаар зардал гарах талаар судалж үзэв.

Монгол Улсын Засгийн газраас гарсан тогтоол шийдвэрийн хүрээнд манай улсад олон улсын чанартай цэргийн хээрийн сургууль, дадлагыг сүүлийн 20 гаран жилийн хугацаанд тогтмол явуулж байна.

Энэхүү оролцож байгаа гадаад улс орны цэргийн багийн бүрэлдэхүүний зэвсэглэл, цэргийн техник, тоног төхөөрөмжийг улсын хилээр нэвтрүүлэхэд гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулах горимд байршуулах бараанд гаалийн

байгууллага импортын гаалийн болон бусад татвар ногдуулж, хураан авч, төрийн сангийн тусгай дансанд байршуулна гэсэн эрх зүйн зохицуулалтын хүрээнд тодорхой мөнгөн дүнг байршуулах асуудал хүндрэл үүсгэдэг. Хүндрэл үүсэж байгаа гол асуудал нь төрийн сангийн тусгай дансанд түр байршуулах мөнгөн хөрөнгө юм.

Тухайлбал, 2021 онд зохион байгуулагдсан Монгол Улс, Оросын Холбоот Улсын батлан хамгаалах цэргийн хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулагдсан “Сэлэнгэ-2021” цэргийн хээрийн сургуульд оролцсон айлын талын зэвсэг, техник, материал хэрэгслийг хилээр нэвтрүүлэхтэй холбогдуулан Гаалийн тухай хуульд заасан эрх зүйн зохицуулалтын хүрээнд 600 000 000 (Зургаан зуун сая) төгрөгийг төрийн сангийн тусгай дансанд байршуулах асуудал үүсэж түүний эх үүсвэрийг гаргах асуудал батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүндрэлтэй нөхцөл байдлыг бий болгож байсан байна.

Улс орны батлан хамгаалах чадавхыг дээшлүүэх зорилгын хүрээнд олон улсын чанартай цэргийн хээрийн сургууль, дадлагад оролцох гадаад улсын орны цэргийн баг бүрэлдэхүүний зэвсэглэл, цэргийн техник, тоног төхөөрөмжийг улсын хилээр нэвтрүүлэхэд гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулах горимд байршуулах бараанд гаалийн байгууллага импортын гаалийн болон бусад татвар ногдуулж, хураан авч, төрийн сангийн тусгай дансанд байршуулахгүй байх эрх зүйн зохицуулалтыг бий болгосноор батлан хамгаалах, Зэвсэгт хүчиний үйл ажиллагааны бэлэн байдал сайжрах, хуулиар хулээсэн чиг үүргээ гүйцэтгэх чадавхи нэмэгдэх, төсвийн үр ашигтай, хэмнэлттэй захиран зарцуулалт хийгдэх боломж бүрдэх юм.

Мөн дээр дурдсан боломжуудаас гадна Батлан хамгаалах, Зэвсэгт хүчиний талаар баримтлах бодлого, зорилго, зорилтоо хэрэгжүүлэхэд томоохон дэмжлэг болохын зэрэгцээ цэргийн алба хаагч нарын сургалт бэлтгэлийн түвшин дээшлэх, давуу талууд бий болох бөгөөд улсын төсөвт нэмэлт зардал гарах зохицуулалтыг хуулийн төсөлд агуулаагүй тул Гаалийн тухай хуульд холбогдох зохицуулалтыг тусгаснаар улсын төсөвт шинээр зардал бий болохгүй болно.

—оОо—